



Go Nomadic Үзэсгэлэнт байгаль, нүүдэлчдийн орон

Монголын Аялал жуулчлалын танилцуулга



МОНГОЛ улс

Монгол бол БНХАУ, ОХУ-тай хиллэдэг өргөн уудам нутаг, нүүдлийн соёлтой орон юм. 2021 оны 7-р сард Чингис Хаан Олон улсын нисэх буудал нээгдсэн ба Аялал жуулчлалын салбарын хөгжил дэвшил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулна хэмээн найдлага тавьж байна.



Монгол Улсын товч танилцуулга



Үндсэн мэдээлэл



Хүн ам
3.3 сая орчим
(2020 он)



Газар нутаг
1564.1 мянган км²
(Японы газар нутгаас 4 дахин том)



Дотоодын нийт бүтээгдэхүүн
13 тэрбум ам.доллар



1 хүнд ногдох ДНБ
4167 ам.доллар
(2020 он)



Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ
29.6 тэрбум ам.доллар
(1996-2020 он)



ДНБ-ий өсөлт
5.1%
(2021 оны урьдчилсан таамаглал)



Экспорт 7.6 тэрбум ам.доллар
Импорт 5.3 тэрбум ам.доллар
(2020 он)



Инфляцийн түвшин
2.3%
(2020 он)




Экспортын гол нэрийн бараа
Хүрэн нүүрс, зэсийн хүдэр,
алт гэх мэт



Импортын гол нэрийн бараа
Нефтийн бүтээгдэхүүн,
тээврийн хэрэгсэл, машин
механизм, эд анги гэх мэт



Япон улстай Эдийн засгийн
түншлэлийн хэлэлцээр
байгуулсан
(2016 он)



Валютын нэгж
Төгрөг
1 иен = 26 төгрөг
(2021 оны 6-р сарын байдлаар)

Товч түүх

1911 он Манж Чин улсаас тусгаар тогтнож, автономит засгийн газар байгуулав

1921 он Хятадаас тусгаар тогтнолоо зарлав

1924 он Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг байгуулав

1972 он Япон улстай дипломат харилцаа тогтоов

1990 он Социализмаас татгалзаж, олон намын тогтолцоог нэвтрүүлэв

1992 он Үндсэн хуулиа шинэчилж, улсын нэрээ Монгол Улс болгон өөрчлөв



Монгол Улсын төрийн далбаа

Уламжлалт өв соёл

Үндэсний их баяр "Наадам"



Хурдан морины уралдаан



Баяр наадмын нээлтийн ёслол



Монгол бөх



Сур харваа (нум, сум)

Хүн төрөлхтний соёлын биет бус өв "Морин хуур", "Хөөмий" Үндэсний уламжлалт хоол "Боодог"



Олон улсын шинэ нисэх онгоцны буудал



Улаанбаатар хотоос баруун урагш 50 км зайд, Хөшигийн хөндийд байрладаг. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг даган өсөн нэмэгдэж буй агаарын тээврийн эрэлт хэрэгцээ, ялангуяа олон улсын нислэгийн хэрэгцээг хангахын тулд 2021 оны 7-р сарын 4-нд шинээр нээгджээ.




Сүхбаатарын талбай болон хүндэт харуул



Чингис Хааны хөшөө



Улсын Дуурь Бүжгийн
Эрдмийн Театр



Засгийн газрын ордон

Улаанбаатар

Улаанбаатар хот нь Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн төв бөгөөд Монголын газар нутгийн төв хэсэгт далайн түвшнээс дээш 1300 метрийн өндөрт оршдог. Богд хан, Сонгино хайрхан, Чингэлтэй, Баянзүрх хэмээх 4 уулаар хүрээлэгддэг



Чойжин ламын сүм музей



Богд хааны ордон музей





Зайсан толгой

Улаанбаатар



Япон цэргийн дурсгалд зориулсан цогцолбор




Гандантэгчэнлин хийд



Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей



Анхдугаар Богд Жавзандамба хутагт Өндөр гэгээн Занабазарын урласан бурхад



**3 шөнө/
4 өдөр** **Богино хугацааны аяллын хөтөлбөр**

Эхний өдөр **Улаанбаатарт хүрэх**

2 дахь өдөр **Улаанбаатар хоттой танилцах**
Сүхбаатарын талбай, Монголын Үндэсний Музей, Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Зайсан толгой Тэрэлж зэрэг хотод ойрхон газар гэрт хоноглох

3 дахь өдөр **Монгол соёлтой танилцах**
Бэсрэг наадам үзэх, байгаль судлах, цэцэг ургамал үзэж сонирхох, морь унах, үндэсний дуу хөгжим сонсох
Үдээс хойш Улаанбаатар хотод худалдан авалт хийх
Оройн зоог Монгол хоол, Улаанбаатар хотын зочид буудалд хоноглох.

4 дэх өдөр **Улаанбаатараас хөдлөх**

Өмнөговь аймаг




Өмнөговь аймгийн Даланзадгад хот хүртэл онгоцоор 1 цаг, машинаар 8 цаг зарцуулна. Машинаар явах тохиолдолд өргөн уудам тал хээр нутгаар дайран өнгөрөх ба зам дагуу бэлчиж буй тэмээн сүрэг зэрэг амьтдыг харах боломжтой.



Хонгорын элс


Тас шувуу



Аргаль



Алтайн хойлог



Баянзаг





Хэрмэн цав



Шилүүс






Үлэг гүрвэлийн чулуужсан мөр



Мануул

Өмнөговь аймаг

Тэмээний баяр-Өвлийн наадам



5 шөнө/
6 өдөр

Улаанбаатар хот, Хонгорын Элс

Эхний өдөр Улаанбаатарт хүрэх

2 дахь өдөр Улаанбаатар хоттой танилцах

Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Гандантэгчэнлин хийд, Зайсан толгой, Япон цэргийн дурсгалд зориулсан цогцолбор, үндэсний дуу хөгжим сонсох
Үдийн зоог Монгол хоолны ресторан, оройн зоог Япон хоолны ресторан

3 дахь өдөр Даланзадгад руу нисэх (онгоц)

Үдийн зоогийн дараа Хонгорын элсийг зорих. Оройн зоогийг дуу хөгжим сонсонгоо Монгол үндэсний хоол зооглох. Жуулчны баазад хоноглох.

4 дэх өдөр Хонгорын элс (элсэн манхан)

Морь, тэмээ унах. Үлэг гүрвэлийн чулуужсан өндөг олдсон Баянзагийн зүг хөдлөх. Гэрт хоноглох.

5 дахь өдөр Улаанбаатар хотруу нисэх (онгоц)


Улаанбаатарт буцаж ирснийхээ дараа хотод худалдан авалт хийх. Оройн зоог халуун тогоо.

6 дахь өдөр Улаанбаатараас хөдлөх




Архангай / Өвөрхангай

Монголын эзэнт гүрний эхэн үеийн нийслэл болон цэцэглэн хөгжсөн Хархорин хотын туурь болон түүхийн дурсгал, дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн байгалийн гайхамшигт үзэмжийг үзэх боломжтой.



Эрдэнэ Зуу хийд





Архангай/Өвөрхангай



Хар Балгас хотын туурь



Архангайн өргөн уудам тал хээр



Буган чулуу



Хүн чулуун хөшөө




Түрэгийн үеийн хөшөө дурсгал

Архангай /
Өвөрхангай




Хөшөө Цайдам музей



5 шөнө/
6 өдөр

Улаанбаатар болон Хархорины аяллын хөтөлбөр

Эхний өдөр Улаанбаатарт хүрэх



2 дахь өдөр Улаанбаатар хоттой танилцах
Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Гандантэгчэнлин хийд, Зайсан толгой, Япон цэргийн дурсгалд зориулсан цогцолбор, үндэсний дуу хөгжим сонсох
Үдийн болон оройн зоог Монгол хоолны ресторан

3 дахь өдөр Монгол соёлтой танилцах
Монгол номадик бааз, Монгол адууны өвөг тахь
Үдийн зоог Хоёр Загал жуулчны баазад. Элсэн манхан болон тэмээ. Малчин айлд зочлох.
Хархоринруу хөдлөх. Гэрт хоноглох.

4 дэх өдөр Хархорины аялал
Хархорум музей, Эрдэнэ Зуу хийд, Үдийн зоогийн дараа Түрэгийн үеийн хөшөө дурсгал
Өгий Нуур Гэрт хоноглох

5 дахь өдөр Хөшөө Цайдамын цогцолбор дурсгалыг үзэх
Хөшөө Цайдамын цогцолбор дурсгалыг үзсэний дараа малчин айлд зочлох
Үдээс хойш Улаанбаатар хотод худалдан авалт хийх. Оройн зоог халуун тогоо

6 дахь өдөр Улаанбаатараас хөдлөх

Дорноговь аймаг

Монгол орны зүүн өмнөд хязгаарт байрладаг бөгөөд БНХАУ-тай хиллэдэг. Монголын хамгийн том энергийн төв болон элсэн цөл байдаг ба зэрлэг ан амьтдаар баялаг байгалийн нөөц газар ихтэй, байгалийн унаган төрхөө хадгалсан аялал жуулчлалын газар.




Хамарын хийд



Өлгий хийдийн туурь



Өвгөн суварга



Энергийн төв



“Их нарт” байгалийн нөөц газар



“Загийн ус” байгалийн нөөц газар




Эргэлийн зоо



Бүрдэнэ булаг



Сүйхэнт уул (Чулуужсан ой)



Чойрын Богд уул



Говийн Бага дархан цаазат газар









Хүсэл, сонирхолд нийцүүлэн санал болгох аялал





Загасчлах аялал




Уулын ургамал үзэх аялал



Эрвээхэй үзэх аялал



Зэрлэг шувуу ажиглах аялал



Япон болон Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хоорондын харилцаа, хамтын ажиллагаа (Үр дүн, хэтийн төлөв)

Эгч дүүс хот/найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Япон, Монголын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хооронд харилцаа, хамтын ажиллагааны олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжиж байна. Монгол ажилтан болон Гадаад харилцааны Монгол зохицуулагч (CIR: Coordinator for International Relations) ажилладаг Японы орон нутгийн засаг захиргааны байгууллага ч байдаг бөгөөд Ковид-19 цар тахлын энэ үед ч хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг явуулж байна.

Эгч дүүс хот / найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон хамтын ажиллагааны гэрээ байгуулсан он/сар (2021 оны 2-р сарын байдлаар)

Япон улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан он/сар
Нагасаки муж Мацуура хот	Өвөрхангай аймгийн Хужирт сум (хамтын ажиллагаа түр зогссон)	1991/7
Хёого муж Тоёока хот	Баянхонгор аймгийн Богд сум (хамтын ажиллагаа одоогоор зогссон)	1994/10
Тоттори муж	Төв аймаг	1997/7
Миязаки муж Мияконожо хот	Улаанбаатар хот	1999/11
Нагано муж Саку хот	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг	2008/8
Шизуока муж	Дорноговь аймаг, Сэлэнгэ аймаг	2011/7
Осака муж Изүмисано хот	Төв аймаг	2013/7
Шизуока муж Изүнокүни хот	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг	2015/8
Нийгата муж Яхико тосгон	Төв аймгийн Эрдэнэ сум	2016/8
Шизуока муж Яйзу хот	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	2018/8
Хоккайдо муж Такикава хот	Өвөрхангай аймаг	2018/9
Токио хот Мусашимураяма хот	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг (байгуулах төлөвлөгөөтэй)	2021 онд байгуулах төлөвлөгөөтэй байна

Эгч дүүс хот / найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хооронд төлөөлөгчдийн айлчлал / иргэдийн солилцоо, соёлын солилцоо, сургалт зохион байгуулалт, мэргэжилтэн солилцоо, бараа материалар хангах, хувийн хэвшил хоорондын харилцаа гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Орон нутгийн засаг захиргааны олон байгууллага хүүхэд, залуучуудын (дунд, ахлах ангийн сурагчдыг оролцуулаад) харилцан айлчлалыг тогтмол хэрэгжүүлж байна.

Сургалт болон найрамдлын солилцооны хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн тайлан, сэтгэгдэлд "Энэ удаагийн нандин дурсгалаа цаашид ч мартаггүй байхыг хүсэж байна", "Монголоос буюу өөр өнцгөөс Японыг харж мэдрэх завшаан тохиолдсонд, мөн Монголд очиж чадсандаа үнэхээр их байртай байна" гэсэн байгаагаас хүүхдүүдэд ч маш гүн сэтгэгдэл төрүүлсэн байгаа нь харагдаж байна.

Хоёр улсын Засгийн газар, Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиох 2022 оныг "Хүүхэд, залуучуудын найрамдал, солилцооны жил" болгохоор тохиролцсон юм. Хүүхэд, залуучуудын солилцоо нь цаашид "Гадаадад суралцах аялал" хэлбэрээр явагдаж, энэ нь аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулах найдлага төрүүлж байна.



“Хост таун” хөтөлбөр

“Хост таун” хөтөлбөр гэдэг нь, "Токиогийн Олимп, Паралимп 2020" -д оролцож буй улс орон, бүс нутгийн иргэд спорт, соёл, эдийн засаг зэрэг төрөл бүрийн салбарт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар орон нутгийг сэргээн хөгжүүлэх, улмаар Олимп дууссаны дараа ч он удаан жил хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг зорилго болгосон хөтөлбөр юм.



“Хост таун” хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагууд (2021 оны 2-р сарын байдлаар)

Орон нутгийн засаг захиргааны байгууллагын нэр	Спортын төрөл	Бүртгүүлсэн он	Үндэслэл
Аомори муж Имабэцу хот	Туялзуур сэлэм	2016	Туялзуур сэлэмний спорт хөгжсөн хотын хувьд урьсан
Ибараки муж Сакурагава хот	Буудлагын спорт	2017	Буудлагын дасгалжуулагч нь уг хотын иргэн
Ибараки муж Широсато хот	Каратэ	2018	Монгол улсыг дэмжин ажилладаг NPO-ын үйл ажиллагаа
Ибараки мужийн Намэгата хот	Хүндийн өргөлт	2019	Хувь хүн Монголын Үндэсний Олимпын Хорооны хүсэлтээр зуучилсан
Токио хот Мусашимураяма хот	Сумо бөхийн чиглэлээр хамтран ажилладаг	2017	Элчин сайдын яам танилцуулсан
Нийгата муж Нийгата хот/ Цубамэ хот/ Госсэн хот/ Нагаока хот/ Яхико тосгон	Пара-Байт харваа	2016	Нийгата муж танилцуулсан, Их дээд сургууль, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа Мэргэжлийн Сумогийн Монгол бөхчүүдтэй харилцаатай байсан
Шизуока муж Изүнокүни хот	Жүдо бөх, Параспорт	2016	Ерөнхий консул танилцуулсан
Шизуока муж Яйзу хот	Чөлөөт бөх, паралимпын хөнгөн атлетик, сагсан бөмбөгийн 3x3 төрөл, пара таеквондо	2016	Мужийн орон нутгийн засаг захиргааны байгууллагын санаачилгаар, чөлөөт бөхийн спорт хөгжсөн хот
Шизуока мужийн Шимада хот	Боксын спорт	2017	Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа
Айчи мужийн Оказаки хот	Байт харваа	2019	Их дээд сургууль, найрамдлын нийгэмлэгүүд зуучилсан
Осака муж Изүмисано хот	Хөнгөн атлетик (марафон гүйлт)	2017	Найрамдалт хотын харилцаагаа хөгжүүлэх
Ойта муж Уса хот	Таеквондо	2018	Мэргэжлийн Сумогийн Монгол бөхчүүдтэй харилцаатай
Миязаки муж Мияконожо хот	Чөлөөт бөх	2016	Хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа

Монголд бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхэд зөвлөгөө авах газар

1 Монгол-Японы Төв



<https://mongol-japan-center.tumblr.com/>

2 Японы Гадаад худалдааны байгууллага (JETRO)



<https://www.jetro.go.jp/worldtop/asia/mn/fdi/>

3 Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим / Япон



<https://www.mnccij.org/>

4 Монгол дахь Японы бизнесийн зөвлөл



<http://www.jbcm.mn/>

Хэрэг болох мэдээллийн эх сурвалж (вэбсайт болон холбоо барих мэдээлэл гэх мэт)

1 Гадаад Хэргийн Яам (Япон улс)



<https://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/index.html>

2 Монгол дахь бизнесийн орчны гарын авлага 2020



https://www.jica.go.jp/mongolia/office/activities/environment_guide/index.html

3 JICA-ын Гадаад улс орнуудын орон нутгийн мэдээлэл



https://www.jica.go.jp/priv_partner/case/field/index.html#toushi

4 Японы Гадаад худалдааны байгууллага (JETRO)



<https://www.jetro.go.jp/world/asia/mn>

5 Гадаад Харилцааны Яам (Монгол улс)



<http://mfa.gov.mn/en/>

6 Монгол улсаас Япон улсад суугаа Элчин Сайдын Яам



<https://tokyo.embassy.mn/jpn/>

7 Монголын Иргэний Агаарын Тээвэр (МИАТ)



<http://miat-air.jp/>

[Энэхүү танилцуулгын талаар холбоо барих]
ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар
Хаяг ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар Төв шуудан 682, Улаанбаатар 211213, МОНГОЛ
Утас: +976-11-325939 Имейл хаяг: mg_oso_rep@jica.go.jp

Зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно